



Japan
Fund for
Poverty
Reduction



L3605/G9191 : MON48076 - ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ХАНГАХ ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ

АЖЛЫН ДААЛГАВАР

ЖЕНДЕРИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

А. ТАНИЛЦУУЛГА

Монгол улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банктэй зээлийн гэрээ байгуулж (Зээлийн дугаар 3605) “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах үйлчилгээг сайжруулах төсөл” (цаашид “Төсөл” гэх)-ийг хэрэгжүүлэхээр зөвшилцөлд хүрсэн. Тус төсөл нь Монгол Улсын Засгийн Газрыг дэмжин Улаанбаатар хот болон аймгуудын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажил, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, оролцоог дэмжиж үйлчилгээг сайжруулах зорилготой юм.

Дараах цахим хаягаас Төслийн дэлгэрэнгүй мэдээлэлтэй танилцах боломжтой:
<https://www.adb.org/sites/default/files/project-documents/48076/48076-002-rrp-en.pdf>

Жендерийн асуудал хариуцсан мэргэжилтэн нь жендерийн үйл ажиллагааны төлөвлөгөөг (GAP) хянаж, хэрэгжүүлэхэд ХНХЯ болон ТХН-тэй хамтран ажиллах; мөн холбогдох зөвлөхүүдтэй хамтран шаардлагатай тайланг боловсруулж баталгаажуулах үүрэгтэй;

Б. ЗӨВЛӨХ АЖЛЫН ЗОРИЛТУУД

- Жендерийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлж дүгнэх;
- Жендерийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд суурилсан жендерийн асуудлуудыг хэрэгжүүлэх, хянах болон тайлагнахад чиглэсэн удирдлагын хяналтын механизмуудыг байгуулахад ТХН-д туслах, тэдгээрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх;
- Шаардлагатай семинар болон зорилтот бүлгийн хэлэлцүүлэг, уулзалтуудыг зохион байгуулах замаар Жендерийн үйл ажиллагааны төлөвлөгөөний шаардлагуудыг хэрэгжүүлэхэд нь ТХН-д туслалцаа үзүүлэн хамтран ажиллах;
- Жендерийн тодорхой үзүүлэлтүүдийг үнэн зөв цуглуулах, хянах, хураангуй тайланд эдгээр үзүүлэлтүүдийн талаар тусгаж ажиллах;
- Нийгэм болон жендерийн асуудлуудын хэрэгжилтийн хянаж, Жендерийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах үүрэгтэй зөвлөхүүдтэй харилцан хамтран ажиллах, холбогдох баримтуудыг хянаж үнэлэх, шаардлагатай тохиолдолд залруулах арга хэмжээнүүдийг тодорхойлоход нь туслалцаа үзүүлэх;

Зөвлөх нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Жендерийн Үйл Ажиллагааны Төлөвлөгөөнд тодорхойлсон тодорхой үзүүлэлтийн нийгмийн хөгжлийн хэсэг дэх хагас жилийн явцын тайлан болон жилийн хяналтын тайланг бэлтгэхэд ТХН-т дэмжлэг үзүүлэн хамтран ажиллана.